650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	00	70	48	47
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСҮ)	00	05	01	06
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	00	00	00	00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	19	19	00	00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	15	15	22	22
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	08	08	00	00

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>270,797,354.66</b>	<b>303,218,552.66</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>270,797,354.66</b>	<b>303,218,552.66</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>76,083,979.00</b>	<b>233,414,404.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,457,300.00</b>	<b>12,769,800.00</b>
210401	Бичиг хэрэг	247,500.00	468,900.00
210402	Тээвэр, шатахуун	950,000.00	2,244,900.00
210404	Ном, хэвлэл	1,259,800.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	10,056,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>2,973,990.00</b>	<b>48,730,640.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,973,990.00	37,124,090.00
210502	Хоол, хүнс	-	11,606,550.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>80,000.00</b>	<b>58,609,900.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	80,000.00	58,609,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>17,210,999.00</b>	<b>5,757,879.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,210,999.00	5,757,879.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>53,361,690.00</b>	<b>107,546,185.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	53,361,690.00	103,090,280.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	4,455,905.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>194,713,375.66</b>	<b>69,804,148.66</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>178,434,100.00</b>	<b>53,604,500.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	153,496,600.00	30,632,200.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	24,937,500.00	22,972,300.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>16,279,275.66</b>	<b>16,199,648.66</b>
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	16,215,127.66	16,199,648.66
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	64,148.00	-
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>270,797,354.66</b>	<b>310,022,567.66</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>270,797,354.66</b>	<b>310,022,567.66</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	270,797,354.66	310,022,567.66
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		<b>6,804,015.00</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		6,804,015.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад шилэн данс, орлогыг жигд ханган биелүүлэхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Бямбасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дүгээр сарын 07-ны өдрийн 01/23 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн эрхэм зорилго нь сумын хөгжил дэвшлийг эрчимжүүлж, орон нутгийн засаглалыг тогтвортой, мэргэжлийн ур чадвартай байхаар чадавхжуулан, иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрох, ажиллах, амьдрах нөхцөлийг бүрэн хангах бодлого, чиглэлийг тууштай, шуурхай, шударга, хариуцлагатайгаар хэрэгжүүлнэ гэж тодорхойлсон байна.

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлан нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан журмыг баримтлан сумын дотоод хяналт шалгалтыг зохион байгуулж байна. Сумын дотоод хяналтын ажлын хэсгийг 2019 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн А/03 дугаар захирамжаар 5 хүний бүрэлдэхүүнтэй хяналтын комисс нь байгуулан ажилласан байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт дотоод аудитын албанаас Бүрэн сумын төсөвт байгууллагуудын 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 9,000.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг 100% барагдуулж, эрсдэлийн үнэлгээг дунд , ЗДТГ, Соёлын төвд төлбөр зөрчил илрээгүй, эрсдэлийн үнэлгээг бага гэж үнэлсэн байна.

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын

гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын 2,853,169.6 мянган төгрөгөөс 1,0 хувиар буюу 28,531.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 19,972.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн төлөвлөх үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мэдээллээр тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоос дахин тооцож үзэхэд гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоосон материаллаг байдлын түвшин 40,559.1 мянган төгрөг, энэ нь төлөвлөлтийн үе шатнаас 12,027.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн тул материаллаг түвшинг дахин тооцов.

Учир нь төлөвлөлтийн үе шатанд тооцсон нийт орлого 2,853,169.6 мянган төгрөг гүйцэтгэлийн үе шатны орлого 4,055,910.6 мянган төгрөг, 1,202,741.0 мянган төгрөгөөр орлого нэмэгдсэн байна.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Бүрэн сумын Засаг дарга нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ЗЗНДНТУТХ, Шилэн дансны тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хууль болон холбогдох бусад хууль дүрэм зааврыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсөвт байгууллага, төрийн сан, сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, эм эргэлтийн сан, байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан зэрэг 11 санхүүгийн тайланг нэгтгэн тайлагнасан байна.

Санхүүгийн алба нь Сангийн яамны Э тайлангийн нэгтгэлийн систем программыг ашиглаж байна.

#### **Орлогын талаар:**

Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аймгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг 558,220.7 мянган төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжилт 1,532,166.0 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 31,544.4 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн сангийн санхүүжилт 109,124.4 мянган төгрөг, Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөр 160,511.2 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сангийн орлого 65,755.8 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд 293,807.4 мянган төгрөг, орон нутгийн төсвийн орлого 267,768.2 мянган төгрөг, нийт 3,018,898.1 мянган төгрөгийн орлого, эх үүсвэрийг мөнгөн

гүйлгээний тайлангаар төвлөрүүлэн зарцуулсан байна. Санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн төсвийн санхүүжилтийн орлогыг хоорондын тооцоогоор устгал хийсэн байна.

Төв аймгийн Бүрэн сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн орон нутгийн төсөв батлах тухай 03 дүгээр тогтоолд зааснаар Бүрэн сумын Засаг дарга тайлант онд 88,789.3 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсан байна.

Төв аймгийн Бүрэн сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн орон нутгийн төсөв тодотгон батлах тухай 4 дүгээр тогтоолд зааснаар Бүрэн сумын Засаг дарга тайлант онд 88,789.3 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр хэвээр баталж гүйцэтгэлээр 267,768.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 2.0 дахин биелүүлсэн байна.

#### **Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:**

Үндсэн хөрөнгө дансанд 68,536.0 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 1,218,178.2 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор, нийт 1,286,714.2 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн ба 253,064.2 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассан байна.

Бараа материалын дансанд худалдан авсан 336,394.7 мянган төгрөгийн, хандив, бусад эх үүсвэрээр 8,225.4 мянган төгрөгийн, нийт 347,960.4 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 290,710.4 мянган төгрөгийн бараа материалыг данснаас хассан байна.

#### **Авлага, өглөгийн талаар:**

Санхүүгийн нэгтгэсэн тайланд ажиллагчидтай холбогдсон авлага 7,071.1 мянган төгрөг, байгууллагаас авах 20,230.9 мянган төгрөг, хувь хүмүүсээс авах 238,719.3 мянган төгрөг, төлбөртэй үйлчилгээний авлага 172,552.0 мянган төгрөг, зээлийн хүүгийн авлага 13,958.0 мянган төгрөг нийт 452,531.3 мянган төгрөгийн авлага нэгтгэгдсэн. Үүнд: Сургууль 4,493.7 мянган төгрөг, Цэцэрлэг 2,577.4 мянган төгрөг, Эрүүл мэндийн төвийн 172,552.0 мянган төгрөг, ЗДТГ-ын 576.5 мянган төгрөг, Сум хөгжүүлэх сангийн 172,552.0 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сангийн 6,5 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн 20,224.4 мянган төгрөгийн авлагууд байна.

Авлага дансны эхний үлдэгдэл 311,388.2 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 452,531.4 мянган төгрөг болж 141,143.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Авлагын үлдэгдэлд Сум хөгжүүлэх сангийн 253,100.8 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлага 55.92 хувийг, байгууллагаас авах ОНХС-гийн 20,224.2 мянган төгрөгийн, бусад байгууллагын 179,206.4 мянган төгрөгийн авлага 44.08 хувийг эзэлж байна.

Өглөгийн үлдэгдлээр байгууллага, хувь хүмүүсийн өглөг 16,418.1 мянган төгрөг, нийт 20,216.3 мянган төгрөг нэгтгэгдсэн байна. Үүнд: ЗДТГ-ын 2,970.0 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сангийн 5,676.5 мянган төгрөг, Соёлын төвийн 1,278.6 мянган төгрөг, Эмнэлгийн 6,493.0 мянган төгрөгийн өглөг байна. Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 20,912.2 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 16,418.1 мянган төгрөг болж, 4,494.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд Эрүүл мэндийн төв, Соёлын төвийн түлш халаалтын өглөг 7,744.6 мянган төгрөг, ЭЭС-ийн эмийн өглөг 5,676.5 мянган төгрөг, ЗДТГ-ын НДШ-ийн өглөг 2,685.0 мянган төгрөг нийт 16,106.1 мянган төгрөгийн өглөг байна.

#### **Санхүүгийн байдлын тайлангийн талаар:**

Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн харилцах дансанд 412,144.7 мянган төгрөг, арилжааны банк дахь харилцах дансанд эмийн эргэлтийн сангийн 416.9 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд 6,804.0 мянган төгрөг нийт 419,365.6 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна. Төрийн сангийн харилцах дансанд орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл 268,312.7 мянган төгрөг, ОНХС-ийн үлдэгдэл 9,732.9 мянган төгрөг, сум хөгжүүлэх сангийн үлдэгдэл 100,646.8 мянган төгрөг, Эрүүл мэндийн төвийн үлдэгдэл 36,122.3 мянган төгрөг, байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сангийн 4,134.0 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сангийн 416.9 мянган төгрөг байршиж байна.

Бараа материал 315,511.9 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 5,441,885.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/*

<b>Үзүүлэлт</b>	<b>Эхний үлдэгдэл</b>	<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>Өөрчлөлт</b>
<b>Б</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3=2-1</b>
<b>Мөнгөн хөрөнгө</b>	119,116.5	419,365.6	300,249.1
<b>Авлага</b>	311,388.3	452,531.4	141,143.1
<b>Урьдчилгаа</b>			
<b>Бараа материал</b>	258,261.9	315,511.9	57,250.0
<b>Үндсэн хөрөнгө</b>	4,557,313.7	5,441,885.9	884,572.2
<b>Нийт хөрөнгө</b>	5,246,080.4	6,629,294.8	1,380,214.4
<b>Өр төлбөр</b>	20,912.2	16,418.1	-4,494.0
<b>Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/</b>	5,225,168.2	6,612,876.7	1,387,708.5
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	5,246,080.4	6,629,294.8	1,380,214.4

Бараа материалын эхний үлдэгдэл 258,261.9 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 315,512.0 мянган төгрөг болж 57,250.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Бараа материалын үлдэгдэлд тайлант оны эцэст худалдан авсан 38,265.0 мянган төгрөгийн ковидын оношлуур, эм боох материал, 13,115.0 мянган төгрөгийн аж ахуйн материал, 5,867.7 мянган төгрөгийн тусгай зориулалттай материалыг авснаас шалтгаалжээ.

Төв аймгийн Бүрэн сумын Засаг дарга тайлант онд төсвийн хөрөнгөөр 62,689.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 2,336.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 1,601.0 мянган төгрөгийн ном, 1,910.0 мянган төгрөгийн, бусад үндсэн хөрөнгө нийт 68,536.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан байна.

Төв аймгийн Бүрэн сумын Засаг дарга тайлант онд хандиваар 1,046,730.7 мянган төгрөгийн барилга байгууламж, 71,750.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 48,625.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 13,356.9 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 2,624.6 мянган төгрөгийн ном, 33,810.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, 100.0 мянган төгрөгийн программ хангамж нийт 1,224,394.8 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч тайлагнасан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 6,612,876.7 мянган төгрөг болж 1,386,674.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,620,124.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний нийт зарлагыг 2,620,124.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын хүргүүлсэн төсвийн төслөөс 350,541.9 мянган төгрөгөөр бууруулж Бүрэн сумын ИТХ-ын 2020 оны 12 сарын 18-ны өдрийн сумын 2021 оны төсөв батлах тухай 03 дугаар тогтоолд 2,269,582.1 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь эд хогшил, тоног төхөөрөмж, тэтгэмж, урсгал зардлуудыг бууруулж баталсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Бүрэн сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн орон нутгийн төсөв батлах тухай 4 дүгээр тогтоолд зааснаар 53,267.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 2,322,849.4

мянган төгрөгөөр төсвийг тодотгон баталсан байна. Бүрэн сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн орон нутгийн төсөв батлах тухай 4 дүгээр тогтоолд зааснаар Сум хөгжүүлэх сангийн төлөвлөгөөг 180,500.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд Бүрэн сумын Засаг даргын хэрэгжүүлэх 11 хөтөлбөрт зориулан 2,555,122.1 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,235,904.2 мянган төгрөгийг бараа үйлчилгээний урсгал зардалд, 138,717.9 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, эргэж төлөх цэвэр зээлд 180,500.0 мянган төгрөг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,641,290.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 647,010.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 31,627.7 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 235,194.0 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,540,982.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 598,976.1 мянган төгрөг, 31,544.4 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 160,511.2 мянган төгрөгийг нийт 2,332,014.1 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч ОНХС-д 29,593.5 мянган төгрөг, Эрүүл мэндийн төвд 83.8 мянган төгрөг, СХС-д 19,988.8 мянган төгрөгийн санхүүжилт дутуу олгож, 173,442.4 мянган төгрөгийг татан төвлөрүүлж төсвийн тохируулга хийгдсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,263,997.9 мянган төгрөг буюу 88.6 хувьтай байгаа нь цалин хөлс, НДШ-ийн зардал 402,799.9 мянган төгрөг, байр ашиглахтай холбоотой зардал 32,347.9 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 40.7 мянган төгрөг, нормативт зардал 22,188.2 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 23.0 мянган төгрөг, дотоод томилолтын зардал 4,306.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 98.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 8,179.0 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 3.5 мянган төгрөгийн зардлууд хэмнэсэн нь шалтгаалсан байна. Үүнд: сургууль цэцэрлэг ажиллаагүйгээс үдийн цай хөтөлбөр хэрэгжээгүй, илүү цагийн хөлс олгоогүй, бага сургууль ашиглалтад ороогүйгээс халаалтын зардал хэмнэсэн зэргээс шалтгаалсан байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 100,308.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын 4 төсөл, арга хэмжээнд 138,717.9 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 128,868.9 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Бүрэн сумын Засаг дарга дээд шатны төсвийн захирагчаас 310,022.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, үүнээс хангамж, бараа материалын зардалд 12,769.8 мянган төгрөг, нормативт зардалд 48,730.6 мянган төгрөг, эд хогшлын зардалд 58,609.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 5,757.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 107,546.2 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох мөнгөн тэтгэмж 30,632.2 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 22,972.3 мянган төгрөг олгож, нийт 303,218.6 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 16,199.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Мета менежмент ХХК-ийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар барьсан 955,455.8 мянган төгрөгийн Засаг даргын Тамгын газрын контор ашиглалтад орж, 29,700.0

мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий өвсний нөөцийн байр, хашаа, 60,000.0 мянган төгрөгийн төсөвт өртгөөр сумын төвийн төв гудамжинд дулааны шугамын ажил хийгдсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 7,200.0 мянган төгрөгөөр пресслэгч машин худалдан авч хоггүй Монгол ТББ-тай хамтран хог ангилан ялгах сургалт явуулж хогийн цэгийн хогийг ангилан ялган ангилж, Цэцэрлэгийн гадна талын хашааг 4,110.0 мянган төгрөгөөр шинэчлэн засварласан байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн харьяа байгууллагууд, тусгай зориулалттай сангуудын санхүүгийн тайлангийн аудитын талаар:

- Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудиторууд нь тус сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, ИТХ, Соёлын төв, ОНХС, СХС-ийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгасан. Аудитаар ЗДТГ-ын санхүүгийн тайланд 955,485.6 мянган төгрөгийн залруулга хийгдэж, 20,211.9 мянган төгрөгийн албан шаардлага, 5 зөвлөмж өгөгдсөн.
- Төв аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний үндсэн дээр Дунд манхайдай Аудит ХХК тус сумын ЕБС, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, эмийн эргэлтийн сан гэсэн 4 санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан. Аудитаар ЕБС-ийн санхүүгийн тайланд 2,448.8 мянган төгрөгийн 3 акт, 5 зөвлөмж, Цэцэрлэгийн санхүүгийн тайланд 331,8 мянган төгрөгийн 1 акт, 3 зөвлөмж, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд 37,515.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,186.4 мянган төгрөгийн 2 акт, 27,423.4 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 5 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 136 мэдээллээс хугацаандаа оруулсан 104 мэдээлэл, хугацаа хоцроосон 32 мэдээлэл, мэдээлээгүй 1 мэдээлэл байна. Тус байгууллага 5,0 саяас дээших орлогын 4, зарлагын 22 гүйлгээ байршуулж, 5,0 саяас дээших худалдан авалтын 22 гүйлгээ байршуулсан байна. Өр үүсгэсэн шийдвэрийн талаарх мэдээлэл 192 мэдээлэл байршуулсан байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, нэмэлт санхүүжилтээр зарцуулсан хөрөнгө, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогууд бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус байгууллага 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар хууль тогтоомжтой холбоотой, орон нутгийн орлого бүрдүүлэлтэй холбоотой 1 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн Бүрэн сумын Засаг даргын 2021 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 13 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагад балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 33,609.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,180.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж 32,429.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

### 4.2.1 Залруулсан алдаа

1.Тус байгууллага жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг ирүүлэхдээ мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгийн зардлын дүн 1,180.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

### 4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэхтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бүрэн сумын Засаг дарга улсад төвлөрүүлэх 2 нэр төрлийн орлогын төлөвлөгөөг 2,753.9 мянган төгрөгөөр, аймагт төвлөрүүлэх 2 нэр төрлийн орлогын төлөвлөгөөг 381.3 мянган төгрөгөөр, орон нутагт төвлөрүүлэх 9 нэр төрлийн орлогын төлөвлөгөөг 25,225.1 мянган төгрөгөөр нийт 28,360.3 мянган төгрөгөөр тасалсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Улс, аймаг, орон нутагт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлэх.

#### 2. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Төв аймгийн Бүрэн сумын Засаг дарга тайлант хугацаанд оруулбал зохих 136 мэдээллээс хугацаандаа оруулсан 104 мэдээлэл, хугацаа хоцроосон 32 мэдээлэл, мэдээлээгүй 1 мэдээлэл байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-т “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3-д

“тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж мэдээллийг цаг хугацаанд нь мэдээлж ажиллах.

### 3. Худалдан авалттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

1.ИТХ тайлант онд худалдан авалт бүрд е баримт болох анхан шатны төлбөрийн баримтаар баталгаажсан эсэхийг тулган шалгахад 1,706.3 мянган төгрөгийн 3 байгууллагын гүйлгээ е баримтаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QRкодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авалт бүрд е баримт болох анхан шатны төлбөрийн баримтаар Татварын нэгдсэн системд баталгаажуулж байх.

2.Соёлын төв тайлант онд худалдан авалт бүрд е баримт болох анхан шатны төлбөрийн баримтаар баталгаажсан эсэхийг тулган шалгахад 1,962.9 мянган төгрөгийн 3 байгууллагын гүйлгээ е баримтаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QRкодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:худалдан авалт бүрд е баримт болох анхан шатны төлбөрийн баримтаар Татварын нэгдсэн системд баталгаажуулж байх.

### 4.Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

1.Соёлын төвийн даргын 2021 оны 12 сарын 16-ны А/14 тоот тушаалаар шинэ жилийн арга хэмжээнд 250.0 мянган төгрөг, дурсгалт газар хамгаалахад 150.0 мянган төгрөг нийт 400.0 мянган төгрөг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

**Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Санхүүгийн тайлангийн аудитын асуудал</b>											
1	Засаг дарга	2	29,540.3	1	1,180.0					1	28,360.3
2	Ерөнхий боловсролын сургууль	12	128,354.9	3	24,359.1	3	2,448.8	1		5	101,547.0
3	Хүүхдийн цэцэрлэг	5	13,547.1			1	331.6	1		3	13,215.5
4	Соёлын төв	2	2,362.9							2	2,362.9
5	Эргэлтийн эмийн сан	3	14,571.5							3	14,571.5
6	Эрүүл мэндийн төв	11	138,283.4	1	37,515.9	2	1,186.4	3	27,423.40	5	72,157.7
7	Бүрэн сумын ОНХС	4	167,911.2							4	167,911.2
8	Засаг даргын тамгын газар	6	979,570.5	1	955,485.6			3	20,211.9	2	3,873.0
9	Бүрэн сумын ИТХ	1	1,706.3							1	1,706.3
10	Сум хөгжүүлэх сан	2	69,389.8					1	66,196.5	1	3,193.3
11	Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан										
<b>Дүн</b>		<b>48</b>	<b>1,545,237.9</b>	<b>6</b>	<b>1,018,540.6</b>	<b>6</b>	<b>3,966.8</b>	<b>9</b>	<b>113,831.8</b>	<b>27</b>	<b>408,898.7</b>
<b>Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b>											
1	Засаг дарга	1								1	
2	Ерөнхий боловсролын сургууль	2	56,429.3							2	56,429.3
3	Хүүхдийн цэцэрлэг	1	-							1	-
4	Эргэлтийн эмийн сан	1	-							1	-
5	Эрүүл мэндийн төв	1	-							1	-
<b>Дүн</b>		<b>6</b>	<b>56,429.3</b>							<b>6</b>	<b>56,429.3</b>
<b>Нийт дүн</b>		<b>54</b>	<b>1,601,667.20</b>	<b>6</b>	<b>1,018,540.6</b>	<b>6</b>	<b>3,966.8</b>	<b>9</b>	<b>113,831.8</b>	<b>33</b>	<b>465,328.0</b>

**6. Санал дүгнэлт өгсөн байгууллага**

№	Байгууллагын нэр	Санал дүгнэлтийн хэлбэр				
		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс	Дүн
1	ЗДТГ	1				1
2	Ерөнхий боловсролын сургууль	1				1
3	Хүүхдийн цэцэрлэг	1				1
4	Эрүүл мэндийн төв	1	1			1
	<b>Дүн</b>	<b>3</b>	<b>1</b>			<b>4</b>

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)